ВИДЕО МЭДЭЭ · 2023 оны 5-р сарын 11


ПРОКУРОР, ПРОКУРОРЫН ТУСЛАХ АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ТЭМЦЭЭН БОЛЛОО



Прокурорын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, идэвх санаачилгыг нь нэмэгдүүлэх, мөн хувь хүний хөгжлийг дэмжих зорилготой "ПРОКУРОР-2023", "ТУСЛАХ АЖИЛТАН-2023" мэргэжлийн тэмцээн 5 дугаар сарын 08-аас 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын шилдэг 30 прокурор, 32 туслах ажилтан оролцож, хууль эрх зүйн мэдлэгийн сорил, эссэ бичлэг, илтгэх, мэтгэлцэх чадвар, хууль зүйн дүгнэлт хийх, цахим бүртгэлийн систем дээр ажиллах зэрэг 5 төрлөөр ур чадвар, мэдлэг оюунаа сорисон.





“ПРОКУРОР-2023” тэмцээний тэргүүн байранд Завхан аймгийн прокурорын газрын хяналтын прокурор С.Энхзул, дэд байранд Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Г.Янжиндулам, гуравдугаар байранд Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Энх-Эрдэнэ;

“ТУСЛАХ АЖИЛТАН-2023” тэмжээний тэргүүн байранд Дархан-Уул аймгийн прокурорын газрын туслах ажилтан Э.Баасанжаргал, дэд байранд Сэлэнгэ аймгийн прокурорын газрын туслах ажилтан Б.Ануужин, гуравдугаар байранд Ховд аймгийн прокурорын

газрын туслах ажилтан Б.Энхтулга нар тус тус шалгарлаа.





Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан тэмцээний хаалтын үеэр хэлсэн үгэндээ “Аливаа тэмцээн уралдаанд оролцох нь хүнд эерэг хандлага, шинэ боломжийг нээж өгдөг. Тэмцээнд оролцогч та бүхэн өрсөлдөгчөөсөө суралцаж, өөрийгөө үнэлэн дүгнэх хэрэгтэй. Мөн та бүхэн прокурорын байгууллагын ирээдүйн өнгийг тодорхойлогчид учир цаашид өөрийгөө болоод прокурорын байгууллагыг зоргосолтгүй урагшлуулан хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна”

хэмээн онцолсон юм.

Видео: https://www.youtube.com/watch?v=aGbY9qP3DCc

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1872